Барааны нэр төрөл бүртгэх, засах

"Барааны нэр төрөл" модульд дараах үйлдлүүдийг хийнэ:

-	Эм бараа шинээр бүртгэх	2
-	Эм бараа устгах	3
-	Үнэ өөрчлөх, олон салбартай бол салбар бүрээр үнэ өөрчлөх	3
-	Баркод нэмж оруулах, засах	6
-	Идэвхигүй эсвэл идэвхитэй болгох	7
-	Бөөний төвөөс авдаг үнэ харах	9

1. ЦЭС -> "Барааны нэр төрөл" гэж орно.



2. "Барааны нэр төрөл" цонх нээгдэнэ. Энд эм барааны нэр төрлийн жагсаалт байна. Өөрөөр хэлбэл эм барааны үлдэгдэл энд харагдахгүй, үлдэгдлээс бусад мэдээллийг эндээс харах, бүртгэх, засах, устгах боломжтой.

Бар	ааны нэр төрөл								-		×
÷	Шинэ 📝 Засах 💥 Устга	ах	Өртөг харах: 2	024-08-22 🔻 Салбар 1	• 🕎 Ш	Іүүх 🛛 🕎 Баркодо	ор хайх		X E	xcel -pγ	ү гаргах
	Үнийн жагсаалт хэвлэх 🛛 🔒	Бар	окод хэвлэх	Унийн өөрчлөлт Идэвхитэйг ха	ipax 👘	N XX		3			
	Ангилал	1				2		θ	ртөг		
•	[Бүх барааг харах]		Дотоод код	Барааны нэр	 Хэмжих нэгж 	Үндсэн зарах үнэ	Ширхэгийн үнэ	Өртөг	Зөрүү	%	Нийлүүл авсан
	Бусад	٩									*
	Жоргүй эм		8904151802341	Зэстомин 200мл №1	фл	14,000.00		0.00	14,000.00	100.0	
	Жортой эм		4031571030536	Ибу денк шахм 400мг N100, Денк	ш	500.00	0.00	2,148.46	-1,648.46	-329.7	
	Зайлшгүй шардлагатай		4031571058226	Ибу денк шахм 600мг №10	ш	800.00		0.00	800.00	100.0	0
			8656021287146	Ибумон 200мг №10	ш	150.00		0.00	150.00	100.0	U
			8656021287153	Ибумон 400мг №10	ш	200.00		0.00	200.00	100.0	
			5290665002098	Ибупрофен 400мг №10 перофен	ш	120.00		0.00	120.00	100.0	
			5290931002623	Ибупрофен 400мг №10 рупан	ш	150.00		0.00	150.00	100.0	
			6939007605403	Ибупрофен хіпд хіпд 400мг №10	ш	150.00		760.00	-610.00	-406.7	
			5310090008219	Ибупрофен актив сироп 100мл	фл	5,000.00		0.00	5,000.00	100.0	
			5907529462607	Ибуфен 100мл/5мл №1	фл	13,500.00		0.00	13,500.00	100.0	-
			3,829 ц								
		4									Þ

Энд онцлох зүйлсийг дурдвал:

- 1) Анх нээхэд бүх идэвхитэй эм бараа гарч ирнэ. Ангилал хэсгээс харахыг хүссэн ангилал дээрээ дарахад зөвхөн уг ангилалын эм бараанууд гарч ирнэ.
- Идэвхитэй эм барааг шүүж харуулсан байна. Үүн дээр дарвал "Идэвхигүйг харах", "Бүх барааг харах" гэсэн сонголтууд гарч ирнэ.
- 3) Нэг эм бараа дотроо олон баркодтой байж болдог. Тиймээс яг нэг баркод аль бараанд байгааг хайж олохыг хүсвэл энэхүү "Баркодоор хайх" товчийг дарна. Гарч ирэх хүснэгт дээр баркод баганаар нь шүүлт хийж тухайн баркод аль бараанд байгааг олно.

Эм бараа шинээр бүртгэх

Энд бараа шинээр бүртгэхээс өмнө анхаарах зүйлс:

- Програм шинээр ашиглаж эхэлж байгаа эмийн сан, дэлгүүр бол Эхний үлдэгдэл дээр бараагаа бүртгэх нь илүү хялбар.
- Хэрэв эхний үлдэгдлээ оруулаад дууссан бол цаашид "Татан авалт" модулиар барааны орлого авч байх үедээ бүртгэлгүй барааг шинээр бүртгэх нь илүү оновчтой.
- Яг энэ "Барааны нэр төрөл" цонхонд шинээр бараа бүртгэх шаардлага ер нь байхгүй.

Цонхны зүүн дээд булангийн "Шинэ" товчыг дараад гарч ирэх цонх дээр бараа шинээр бүртгэнэ. Дараах цонх нээгдэнэ. Хэрэв Шинэ товч идэвхигүй байвал та шинээр бүртгэх эрхгүй байна гэсэн үг.



Бараа шинээ бүртгэхэд анхаарах зүйлс:

- Ангилал сонгох үед таны хүссэн ангилал бүртгэлгүй бол "…" гурван цэгтэй товчыг дарж Ангилалын жагсаалт бүхий "Барааны ангилал бүртгэх" цонхыг нээж, тэндээ шинэ ангилалаа бүртгээд сонгоно.
- 2) Дотоод код нь орион програм дотор тухайн барааг илэрхийлж буй давхардахгүй код юм. Шинэ бараа бүртгэх үед програм өөрөө давхардахгүй код үүсгэж өгнө. Үүнийг өөрчлөх хэрэггүй. Хүмүүс дотоод код дээр ямар нэг утга илэрхийлсэн код оруулах гээд байдаг, ингэх ямар ч шаардлагагүй шүү. Давхардахгүй код байхад л болно.
- 3) Баркод нь хүснэгт байгааг харж байгаа байх. Энэ нь нэг бараанд олон баркод байж болно гэсэн үг юм.
 - а. Хэрэв баркодгүй бараа бол энд "Дотоод код" -г хуулж оруулна.
- Нэгээс олон баркод бүртгэе гэвэл "Баркодууд" хүснэгтийн доор байгаа энэхүү "+" нэмэх товчийг дарж хүснэгтрүү шинэ мөр нэмж байгаад бүртгэнэ.
- 5) Зарах үнийг энд оруулна. Зарах үнэ оруулахдаа Ширхэгээр оруулах уу, эсвэл Бүхлээр буюу хайрцагаар нь оруулах уу гэдгээ бодож оруулна. Хэрэв тухайн эмийг хаяа ч болов ширхэгээр

зардаг бөгөөд савлалтдаа 30, 28, 14, 7 гэх мэт 5д хуваагдахгүй ширхэгтэй бол Ширхэгээр бүртгэсэн нь дээр.

- a. Ширхэгээр бүртгэнэ гэж яахыг хэлж байна? Ерөөсөө л Зарах үнэ дээрээ ширхэгийн үнэ оруулахыг Ширхэгээр бүртгэх гэж хэлж байгаа юм.
- 6) Хэрэв танайх нэг бааз дотор олон салбартай бол "Үнийн хүснэгт" товчийг дарж Үнийн хүснэгт нээж байгаад салбар бүрээр өөр үнэ оруулах боломжтой.
 - Зарах үнэ салбар бүрээр өөр байж болох ч бүх салбарт нэг хэмжих нэгжийг баримтлах ёстойг хатуу анхаарна уу. Өөрөөр хэлбэл, нэг эм барааны хувьд нэг салбарт ширхэгийн, нөгөө салбарт хайрцгийн үнэ оруулж болохгүй.
 - b. Олон салбартай үед бүх салбарт ижил үнэ баримтлах боломжтой. Үүний тулд манай ажилтанд хандаж тохиргоо хийлгэнэ.

Эм бараа устгах

- 1) Эхлээд устгах бараагаа хүснэгтээс хайж олох ёстой.
 - a. Үүний тулд хүснэгтийн хайлтын мөр буюу эхний хоосон мөр дээр, Барааны нэр талбарт харгалзах нүдэнд хайж буй эмийн нэрээ бичнэ.
 - b. Хэрхэн хайх тухай дэлгэрэнгүйг гарын авлагын "Хүснэгтийг бүрэн ашиглаж сурах" гарчгаас уншиж болно.
- 2) Устгах эм барааны нэр дээр хулганаар очиж хулганы баруун товчийг дараад Устгах коммандыг сонгоно. Хэрэв Устгах товч идэвхигүй байвал та уг үйлдлийг хийх эрхгүй байна гэсэн үг.

Эм бараа устгахад анхаарах зүйлс:

 Хэрэв эм бараа нь орлого, борлуулалт, тооллого зэрэг ямар нэг гүйлгээнд оролцсон бол түүнийг устгах боломжгүй. Ийм үед Идэвхигүй болгох хэрэгтэй. Энэ тухай дараагийн сэдвүүдээс уншина уу.

Үнэ өөрчлөх, олон салбартай бол салбар бүрээр үнэ өөрчлөх

- 1) Эхлээд үнэ өөрчлөх бараагаа хүснэгтээс хайж олох ёстой.
 - a. Үүний тулд хүснэгтийн хайлтын мөр буюу эхний хоосон мөр дээр, Барааны нэр талбарт харгалзах нүдэнд хайж буй эмийн нэрээ бичнэ.
 - b. Хэрхэн хайх тухай дэлгэрэнгүйг гарын авлагын "Хүснэгтийг бүрэн ашиглаж сурах" гарчгаас уншиж болно.
- Эм бараагаа олсон бол түүн дээр хулганаар хоёр дарж нээнэ. Дараах "Бараа материал засах" цонх нээгдэнэ:

Бараа материал засах				
* Нэр:	Ибумон 200мг №10		* E	аркодууд:
* Хэмжих нэгж:	ш	• ··· x		Баркод
* Ангилал:	Зайлшгүй шаардлагата	айэм ▼ … Х	•	8656021287146
* Дотоод код:	8656021287146	/	2	
Yнийн байрлал:	Бүх байрлалд ижил	💷 Үнийн хүснэгт]	
* Зарах үнэ: (MNT)	150	0.00		
	 Ширхэгээр гүйлгээ х Бүхлээр гүйлгээ хий 	(нийнэ ?	+	
Савлалт дахь тоо.ш:	1.00	<u>\1</u>		Зураг Тэмдэглэл
Анхны өртөг:	0.00			

1: "Зарах үнэ" талбарт үнэ засаж бичнэ. Хэрэв танайх нэг бааз дээр олон салбартай бол, мөн салбарууд өөр өөр үнэтэй байж болдог бол, энд зассан үнэ яг дээр нь байгаа "Үнийн байрлал" дахь салбарын үнийг л өөрчлөнө гэдгийг анхаарна уу.

2: "Үнийн хүснэгт" товчыг олон салбартай үед салбар бүр дээрхи үнийг засахыг тулд ашиглана.

Зарах үнэ засах, өөрчлөхдөө анхаарах зүйлс:

- 1) Үнэ өөрчлөхдөө нэгж сольж өөрчилж болохгүйг хатуу анхаарна уу.
 - а. Өөрөөр хэлбэл, нь "Ибупрофен денк 400мг" -н үнэ 450 төгрөг буюу ширхэгээр байхад шууд 5,000 болгож болохгүй, учир нь 5,000 бол трүпийн үнэ юм. Энэ нь та үнэ засахдаа ширхэг байсныг трүп болгочлоо гэсэн үг. Гэтэл програм дахь уг эмийн бүх гүйлгээ, үлдэгдэл нь ширхэгээр явж байгаа. Зарах үнийг шууд трүп болголоо гээд програм үүнийг ойлгож үлдэгдлийг нь трүпрүү автоматаар хөрвүүлж чадахгүй. Тиймээс уг эм барааны үлдэгдэл зөрөх нөхцөл бүрдэж байгаа юм.
 - b. Хэрэв зардаг нэгжийг нь өөрчлөх зайлшгүй шаардлага байгаа бол тухайн эм барааны үлдэгдлийг шинэ нэгжрүү хөрвүүлэх ёстой. Үүнийг хийдэг "Нэгж хөрвүүлэх" үйлдэл програмд байдаг. Гэхдээ заавал манай ажилтантай холбогдож заавар зөвлөгөө авч байж нэгж хөрвүүлэх ёстой шүү.
- 2) Үнийн өөрчлөлтийн түүхийг орион програм хөтөлдөг. Уг түүхийг харахын тулд эхлээд тухайн бараагаа нээнэ (Нээнэ гэдэг нь "ЦЭС -> Барааны нэр төрөл" гэж ороод, хүснэгтээс бараагаа хайж олоод, дээр нь хулганаар хоёр дарж нээхийг хэлж байгаа юм). Зарах үнэ талбарын арын "…" гурван цэгтэй товчийг дарахад "Үнийн өөрчлөлтийн түүх" цонх нээгдэнэ. Эндээс хэн гэдэг хэрэглэгч хэзээ зарах үнэ ямар байхад ямар болгож өөрчлөлт оруулсан нь дэлгэрэнгүй харагдана.

γ	нийн өөрчлөлтийн түүх	- 0	×									
	Үнэ оруулсан огноо	Үндсэн үнэ	Ширхэгийн үнэ	Үнийн байрлал	Бүртгэсэн хэрэглэгч							
۲	2022-01-19 18:41 🔹	4,500.00		Pharmacy	admin							
	2022-01-19 18:41	4,500.00		Бөөний төв	admin							
	2022-01-18 19:47	1,500.00		Бөөний төв	admin							
	2021-10-29 18:39	1,500.00		Pharmacy								
	2020-08-15 13:40	1,200.00		Pharmacy								
	5 w											
	Энд хийгдсэн үйлдэл шууд системд хадгалагдана гэдгийг анхаарна уу! Хаалт хийсэн бол түүнээс урагш байгаа үнийн түүхийг засварлах боломжгүй! Гуцах											

- 3) Хүмүүсээс "Би үнэ өөрчлөөгүй байхад үнэ өөрлөгдөөд байна" гэдэг асуулт хааяа ирдэг. Үүнд тайлбар өгье:
 - a. Зарах үнийг эрх бүхий хэрэглэгч гараараа л өөрчлөнө. Програм автоматаар өөрөө зарах үнэ өөрчлөх боломжгүй!
 - b. Хэзээ ямар хэрэглэгч үнэ өөрчилснийг харья гэвэл дээр тайлбарласан "Үнийн өөрчлөлтийн түүх" -рүү орж харна.
 - с. Нэг бааз дээр олон салбартай бөгөөд зарах үнэ бүх салбарт ижил байдаг тохиргоотой газар заримдаа будилах нь тохиолдол бий. Жишээ нь, ижил үнэтэй байх тохиргоотой гэдгээ мартаад, нэг барааны үнийг салбараар ялгаатай оруулах гэж оролддог. Гэтэл үнэ хөдөлгөх бүрт бусад салбарын үнэ зэрэг өөрчлөгдөнө. Ийм үед бусад салбар дээрхи үнэ өөрөө хөдөлсөн мэт андуурагдах тохиолдол бий.
 - Эмийн сан, дэлгүүрийн өөр ажилтан үнэ өөрчилснийг мэдэлгүй, үнэ яагаад өөрчлөгдснийг манайхаас асуусан тохиолдлууд бий. Нэг бол бусад хэрэглэгч үнэ өөрчлөх эрхтэй, эсвэл эрхлэгч/эзний нэвтрэх эрхээр бусад ажилтан ордог гэсэн үг.

Ийм үед өөрийн нэвтрэх нууц үгээ өөрчлөх болон бусад хэрэглэгчийн хандах эрхийн тохиргоог манайхаар шалгуулан дахин тохируулж болно.

- е. Борлуулалт засахдаа зарсан үнэ өөрчилж болно. Үүнийг борлуулалт засах эрх бүхий хэрэглэгч хийнэ. Эмийн сангийн нэг ажилтан нь ийм засвар хийснийг өөр ажилтан/эрхлэгч мэдэлгүй, програм өөрөө үнэ өөрчилсөн мэтээр буруу ойлгох тохиолдол гардаг. Тухайн борлуулалтын "Өөрчлөлтийн түүх харах" цонхруу ороход хэзээ хэн гэдэг хэрэглэгч зарах үнийг ямар байхад нь ямар болгож өөрчилсөн нь харагддаг (Энэ тухай гарын авлагын "Борлуулалт засах, буцаах, устгах" сэдвээс дэлгэрэнгүй харж болно). Цаашид ийм буруу ойлголт үүсгэхгүй байя гэвэл:
 - i. Нэгдүгээрт, админ хэрэглэгчийн нууц үгийг солиод, эрхлэгч нь зөвхөн өөрөө нэвтэрдэг байх ёстой.
 - ii. Хоёрт, бусад хэрэглэгчийн хандах эрхийн тохиргоог манайд хандаж шалгуулаад, хэрэв борлуулалт засах эрхтэй бол болиулах хэрэгтэй.
- 4) Зарах үнэ өөрчлөх боломжууд:
 - а. "Барааны нэр төрөл" -рүү орж зарах үнэ өөрчлөх боломжтой.
 - b. "Татан авалт" модуль дээр бөөний төвөөс ирсэн барааг орлого авч байх үедээ өөрчлөх боломжтой. Энэ нь илүү оновчтой арга. Учир нь бөөний төвөөс тухай барааны авдаг үнэ нэмэгдээд ирсэн бол орлого авч байхдаа цаг алдалгүй зарах үнээ нэмдэг байх хэрэгтэй юм. Тиймээс Татан авалт буюу барааны орлого авах эрхтэй хэрэглэгч мөн зарах үнэ өөрчлөх эрхтэй байдаг.
 - с. "Эхний үлдэгдэл оруулах" модуль дээр нэгэнт бүртгэсэн барааны үнийг өөрчлөх боломжтой. Гэхдээ эхний үлдэгдэл шивж байхдаа зарах үнээ буруу оруулсан үед л очиж засна. Харин эхний үлдэгдлээ зөв шивээд дууссан бөгөөд түүнээс хойш үүссэн өөрчлөлтийг эхний үлдэгдэлрүү очиж хийнэ гэдэг бол эхний үлдэгдэл гэдэг зүйлээ агуулгын хувьд маш буруу ойлгосны шинж юм.

Баркод нэмж оруулах, засах

- 1) Эхлээд баркод оруулах бараагаа хүснэгтээс хайж олох ёстой.
 - a. Үүний тулд хүснэгтийн хайлтын мөр буюу эхний хоосон мөр дээр, Барааны нэр талбарт харгалзах нүдэнд хайж буй эмийн нэрээ бичнэ.
 - b. Хэрхэн хайх тухай дэлгэрэнгүйг гарын авлагын "Хүснэгтийг бүрэн ашиглаж сурах" гарчгаас уншиж болно.
- 2) Эм бараагаа олсон бол түүн дээр хулганаар хоёр дарж нээнэ. Дараах "Бараа материал засах" цонх нээгдэнэ:

Бараа материал засах					-		×
* Нэр:	Ибумон 200мг №10	*	Баркодууд:				
* Хэмжих нэгж:	ш т.	x	Баркод		Бүртгэсэн о	гноо	
* Ангилал:	Зайлшгүй шаардлагатай эм 🔻 •	x	8656021287146		2018-01-19 12:	:37	
* Дотоод код:	8656021287146	- 0	8656021287753				
ҮНЭ ☑ Үнийн байрлал:	Бүх байрлалд ижил 💷 Үнийн Салбар 1	н хүснэгт	/ ²	1			
* Зарах үнэ: (MNT)	150	0.00	/	2 ш			
	 Ширхэгээр гүйлгээ хийнэ Бүхлээр гүйлгээ хийнэ 	?	+).				
Савлалт дахь тоо.ш:	1.00		Зураг Тэмдэглэл	Сери Нэ	мэлтүүд Бу	/сад	
Анхны өртөг:	0.00					2	

1: "Баркодууд" хүснэгт дотор баркодоо засаж бичнэ.

2: Эм бараа нэгээс олон баркодтой байж болох бөгөөд олон баркод оруулахын тулд "Баркодууд" хүснэгтийн доор байгаа "+" нэмэх товчийг дарж хүснэгтрүү мөр нэмж байгаад шинэ баркодоо бүртгэнэ.

Идэвхигүй эсвэл идэвхитэй болгох

- Юуны өмнө барааг Идэвхигүй болгох ямар хэрэгцээ байдаг вэ гэдгийг бодьё.
 - Хэрэв эм бараа ямар нэг гүйлгээнд (борлуулалт, орлого, зарлага, тооллого г.м) ашиглагдсан бол түүнийг устгах боломжгүй байдаг.
 - Гэтэл уг бараагаар цаашид гүйлгээ хийхгүй, хэрэггүй бол түүнийг ямар нэг байдлаар арилгах ёстой.
 - Ийм үед Идэвхигүй болгоно.
 - Идэвхигүй болгосноор уг бараа шинэ гүйлгээнд гарч ирэхгүй, сонгох боломжгүй болох юм.
 - Гэхдээ, барааг идэвхигүй болгохын өмнө Үлдэгдлийг нь заавал 0 болгох (тэглэх) ёстой.
 - Хэрэв үлдэгдэл нь 0 биш, нэмэх эсвэл хасах утгатай бол түүнийг идэвхигүй болгосон ч борлуулалт дээр харагдсаар байдгийг анхаарна уу.
- 1) Хэрэв барааг Идэвхигүй болгох гэж байгаа бол доорхи зурагт харуулсан талбарт "Идэвхитэйг харах" сонголтыг хийж идэвхитэй бараануудыг харуулж байгаад тэндээсээ идэвхигүй болгох бараагаа хайж олно.

Барааны нэр төрөл						
🛉 Шинэ 📝 Засах 💢 Устгах	c	Өртөг харах: 202	24-08-22 🔻 Салбар 1 🔻	ү Ш	үүх 🛛 🕎 Баркодо	ор хайх
🚔 Үнийн жагсаалт хэвлэх 🛛 🌐	Бар	код хэвлэх 🔰 😭	Үнийн өөрчлөлт Идэвхитэйг хар	ax 🔻	🖹 🔆	
Ангилал			Идэвхитэйг хар	ax		
🕨 👻 [Бүх барааг харах]		Лотоод код	Идэвхигүиг хара Бараан у Бух барааг хара	идэвхигүиг харах Бух барааг харах		Ширхэгийн
[Ангилалгүй бараанууд]		дотоод код	Dapaanin Dix capaan xapa	112170	пдсон зарах унз	үнэ
Бусад	٩					
Жоргүй эм		8904151802341	Зэстомин 200мл №1	фл	14,000.00	
Жортой эм		4021571020526	MEN SOURCE MARK 400ME N100 BOUNC		500.00	0.00

- Харин эсрэгээр, идэвхигүй барааг Идэвхитэй болгох гэж байгаа бол "Идэвхитэйг харах" талбарын утгыг "Идэвхигүйг харах" эсвэл "Бүх барааг харах" гэж сонгож байгаад тухайн бараагаа хайж олно.
- 3) Хүснэгтээс бараа хайхдаа:
 - a. Хүснэгтийн хайлтын мөр буюу эхний хоосон мөр дээр, Барааны нэр талбарт харгалзах нүдэнд хайж буй эмийн нэрээ бичнэ.
 - b. Хэрхэн хайх тухай дэлгэрэнгүйг гарын авлагын "Хүснэгтийг бүрэн ашиглаж сурах" гарчгаас уншиж болно.

4) Эм бараагаа хүснэгтээс олсон бол түүн дээр хулганаар хоёр дарж нээнэ. Дараах цонх нээгдэнэ:

Бараа материал засах		
* Нэр:	Ибумон 200мг №10	* Баркодууд:
* Хэмжих нэгж:	ш ••• х	
* Ангилал:	Зайлшгүй шаардлагатай эм 🔻 🚥 🗙	8656021287146
* Дотоод код:	8656021287146	
ГНЭ	Бүх байрлалд ижил 🔲 Үнийн хүснэг	T
Үнийн байрлал:	Салбар 1	
* Зарах үнэ: (MNT)	150. ··· 0.00	2
	 Ширхэгээр гүйлгээ хийнэ Бүхлээр гүйлгээ хийнэ 	+ -
Савлалт дахь тоо.ш:	1.00	Зураг Тэмд
Анхны өртөг:	0.00	
Одоогийн өртөг:	0.00	
Заавал байх үлдэгдэл:	0.00	
1тавиур:	🗹 Идэвхитэй ашиглагдаж байгаа бол с 👻 … 🗙	онго!
Үйлдвэрлэгч:	• ··· X	
Олон улсын нэршил:		

1: "Идэвхитэй ашиглаж байгаа бол сонго" сонголтыг болиулаад буюу уг checkbox -г uncheck хийгээд хадгална. Хэрэв танайх нэг бааз дээр олон салбартай байдаг бол зөвхөн "Үнийн байрлал" талбар дахь салбар дээр л уг бараа идэвхигүй болох ба бусад салбарт идэвхитэй, харагдсан хэвээр л байна. Бүх салбарт идэвхигүй болгоё гэвэл та "Үнийн хүснэгт" -г ашиглах хэрэгтэй.

2: Хэрэв танайх нэг бааз дээр олон салбартай байдаг бол "Үнийн хүснэгт" -рүү орж салбар бүрээр тухайн барааг идэвхигүй болгох хэрэгтэй. Үүний тулд "**Үнийн хүснэгт**" товчийг дарж дараах цонхыг нээнэ:

		Бараа материал	засах						- 0	×	:	
iF	Үн	ийн хүснэгт	* Нэр: Ибумон 2	00mr №10	¥	* Бај	р кодууд: Барко	д	Бүртгэсэн огноо		- 0	×
н	✓ Бүх байрлалд ижил үнэтэй бол сонго! Савлалт дахь тоо.ш: 1.00 * Хэмжих нэгж: ш ▼ ··· × Үнийн байрлал Үндсэн зарах үнэ Ширхэгийн Зарах хэлбэр Заавал байх Анхны өртөг Одоогийн өртөг						▼ ··· × Одоогийн өртөг	Тавиур	Г	Идэвхитэй	Бүртгэс	
[8	+ 0	Салбар 1	150.00	0.00	Бүхлээр	0.00	0.00	0.00				admin
		anoap z	130.00	0.00	руклар	0.00	0.00	0.00			Ν.	Cumit

"Үнийн хүснэгт" цонх дээрхи "Идэвхитэй эсэх" талбарын сонголт буюу check -г болиулснаар бараа маань тухайн салбар дээр идэвхигүй болно.

Бөөний төвөөс авдаг үнэ харах

- Юуны өмнө Бөөний төвөөс авдаг үнэ буюу Бөөний үнэ нь өртөг биш гэдгийг анхаараарай. Гэхдээ өртгийн тооцоонд ашиглагддаг үнэ юм. *Өртгийн тухай дэлгэрэнгүй сургалт дараа нь манай ажилтнаас авч болно.*
- Мөн энд харуулах Бөөний үнэ нь тухайн эм барааг хамгийн сүүлд авсан үнэ гэдгийг анхаарна уу.
 Эм барааг бөөний төвөөс авах бүрд өөр өөр үнээр ирдэг ба тэдний хамгийн сүүлийн татан авалтын үнийг энд харуулна.
- Ер нь эм барааны бөөний төвөөс авсан сүүлийн үнийг харах ямар хэрэгцээ байдаг вэ?
 - Заримдаа эмийн сан, дэлгүүр дээр улсын янз бүрийн байгууллагаас хяналт шалгалт ордог. Энэ үеэр шалгалтын хүмүүс эм барааны бөөний үнийг гаргаж харуулахыг шаардах тохиолдол бий.
 - Мэдээж танайх өөрсдөө ч ашгаа багцаалдахын тулд уг үнийг харж болно.

Бөөний үнийг харахын тулд ЦЭС -> "Барааны нэр төрөл" гэж ороод доорхи "Барааны нэр төрөл" цонхыг нээнэ:

Ба	араан	ы нэр төрөл											- 🗆	×
4	Ши	нэ 📝 Засах 💥 Устгах	r	Өртөг хара	ax: 2024-08-22	2 🔻 Салбар 1	•	ΨШ	үүх 🛛 🕎 Баркодоо	р хайх			Excel -pyy	гаргах
de la	Ун	ийн жагсаалт хэвлэх 🛛 🔒	Бар	код хэвлэх	🔓 Үнийн	өөрчлөлт Идэв	хитэйг харах	-	la 11		2			_
		Ангилал				θ	ртөг		Бөөний үнз	• (Сүүлийн жи	лд, сүүлд	, татан авсан байд,	паар)	
۲	- [E	Бүх барааг харах]		н зарах үнэ	Ширхэгийн унэ	Өртөг	Зөрүү	%	Нийлүүлэгчээс авсан үнэ	Зөрүү	%	Сүүлд татан авсан огноо	Сүүлийн Нийлуулэгч	Анхн
-		[Ангилалгүй бараанууд] Бусад	٩		1									*
		Жоргүй эм		14,000.00		0.00	14,000.00	100.0	10,500.00	3,500.00	25 %	2023-12-04 10:50	Бусад	
		Жортой эм		500.00	0.00	2,148.46	-1,648.46	-329.7	381.61	118.39	23.7 %	2024-08-09 15:26	Ази фарм:	0
		Зайлшгүй шаардлагатай		800.00		0.00	800.00	100.0	619.85	180.15	22.5 %	2024-06-12 15:54	Ази фарм:	
			×	150.00		0.00	150.00	100.0	110.00	40.00	26.7 %	2023-12-07 16:18	Энто ХХК	
				200.00		0.00	200.00	100.0		200.00	100 %			-
			4		_	\sim	>							Þ

- 1: Хүснэгтийн доор байгаа scroll bar -г хулганаар чирж хойшлуулна.
- 2: "Бөөний үнэ ..." гэсэн бүлэг багануудыг гаргаж ирнэ.
 - "Нийлүүлэгчээс авсан үнэ" талбарт харагдаж буй үнэ бол тухайн барааг хамгийн сүүлд татан авсан бөөний үнэ юм.
 - "Сүүлд татан авсан огноо" талбарт сүүлийн татан авалт хэзээ байсныг харуулсан байна.
 - "Сүүлийн нийлүүлэгч" талбарт сүүлийн татан авалтаа аль бөөний төвөөс хийснийг харуулж байна.